



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 04 өдөр

Дугаар А/107

Мөрөн сум

Газрын зориулалт өөрчлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, Газрын харилцаа, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мөрөн сумын Засаг даргын саналыг үндэслэн 1 иргэний 3 нэгж талбарт гаргасан хүсэлтийн дагуу газар эзэмшүүлсэн аймаг, сумын Засаг даргын холбогдох захирамжид хавсралтад дурдсанаар газрын зориулалтад өөрчлөлт оруулж, эзэмшүүлсүгэй.

2. Уг захирамжаар газар эзэмшиж байгаа иргэнтэй газар эзэмших эрх зүйн баталгаажилт хийж, Улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг), Улсын бүртгэлийн хэлтэс (Б.Мөнгөнзул) нарт тус тус зөвшөөрсүгэй.

3. Захиргааны актыг ажлын 5 хоногийн дотор эрх, ашиг сонирхол хөндөгдөж буй этгээдэд мэдэгдэж, баримтжуулсан захиргааны актыг хувийн хэрэгт бүрдүүлэлт хийж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг)-т үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (М.Алтаншагай), Мэргэжлийн хяналтын газар (Д.Түмэнбаяр) нарт тус тус үүрэг болгосугай

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН

Аймгийн Засаг даргын 2022 оны 04 дүгээр
сарын 04-ний өдрийн А/...107 дугаар
захирамжийн хавсралт



ГАЗРЫН ЗОРИУЛАЛТ ӨӨРЧЛӨХ ИРГЭНИЙ ЖАГСААЛТ

№	Иргэн, хуулийн этгээдийн овог, нэр, регистр	Нэгж талбарын дугаар	Газрын байршил	Эзэмшиж буй газрын зориулалт	Өөрчилж буй газрын зориулалт	Өөрчлөлт оруулж буй захирамжийн багана	Тайлбар
1	Ач хариад овгийн Лааган Тэгшбаяр /РУ75061257/	6712008276	8-р баг 1 дүгээр хэсэг	Гэр бүлийн хэрэгцээ	Үйлчилгээтэй орон сууц	Аймгийн Засаг даргын 2017.01.23-ны өдрийн А/38 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралтын 4 дэх заалтын 4 дэх багана	Газрын зориулалт өөрчлөх
2	Ач хариад овгийн Лааган Тэгшбаяр /РУ75061257/	6712008286	8-р баг 1 дүгээр хэсэг	Худалдаа, нийтийн үйлчилгээ	Үйлчилгээтэй орон сууц	Аймгийн Засаг даргын 2017.01.23-ны өдрийн А/38 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралтын 5 дахь заалтын 4 дэх багана	Газрын зориулалт өөрчлөх
3	Ач хариад овгийн Лааган Тэгшбаяр /РУ75061257/	6712011839	8-р баг 1 дүгээр хэсэг	Худалдаа, нийтийн үйлчилгээ	Үйлчилгээтэй орон сууц	Аймгийн Засаг даргын 2017.01.23-ны өдрийн А/38 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралтын 3 дахь заалтын 4 дэх багана	Газрын зориулалт өөрчлөх